



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 18 өдөр

Дугаар Б/29

Хэрлэн сум

Ж.Гантулгыг ажилд томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.20, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.1, 57 дугаар зүйлийн 57.2.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487 дугаар тогтоолын хавсралт, Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, Улсын Их Хурлын байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 489 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны Арваннаймдугаар хуралдааны 02 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 309 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Удирдах албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтад орж тэнцсэн Жаргалын Гантулгыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд 2023 оны 7 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Ж.Гантулгын үндсэн цалинг ТЗ-2 зэрэглэлээр тогтоон, үндсэн цалин 1,974,000 (нэг сая есөн зуун далан дөрвөн мянга) төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 12 хувиар, зэрэг дэвийн нэмэгдлийг 32 хувиар, орон нутагт ажилласны нэмэгдлийг 40 хувиар, эрх бүхий албан тушаалтны нэмэгдлийг 40 хувиар тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ж.Гантулгад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

D:\My Documents\ Захирамж-2023

231011042